



## УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 8/7

Улаанбаатар хот

Г Б.Дэлгэртүвшинд сахилгын  
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.4, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гаргах журам”-ын 1.3.1, 1.3.3, 6.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын гомдол гаргах журам”-ын 10.1, 10.9, 10.10.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын ахлах бүртгэгч Баатармөнхийн Дэлгэртүвшин албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн нь дотоод хяналт шалгалт болон цуцлахыг Иргэний улсын бүртгэлийн газар (Т.Төгөлдөр)-т, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар (Ж.Аюуш)-т, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар (Б.Ариунболд)-т, хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн санд нэвтрэх эрх цуцлахыг Хяналт шалгалтын газар (Н.Анхбаяр)-т тус тус даалгасугай.

2. Б.Дэлгэртүвшингийн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Иргэний улсын бүртгэлийн газар (Т.Төгөлдөр)-т, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар (Ж.Аюуш)-т, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн санд нэвтрэх эрхийг цуцлахыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газар (Б.Ариунболд)-т, хяналт шалгалт, зөрчлийн нэгдсэн санд нэвтрэх эрх цуцлахыг Хяналт шалгалтын газар (Н.Анхбаяр)-т тус тус даалгасугай.

3. Төрийн болон албаны нууц задруулахгүй байх баталгааг гаргуулж, холбогдох хууль тогтоомжийг сануулахыг нэгжийн нууц хамгаалах ажилтан (Г.Анхныбаяр)-д үүрэг болгосугай.

4. Б.Дэлгэртүвшингийн ажлыг зохих журмын дагуу хүлээлцэж, 589 дугаартай улсын ахлах бүртгэгчийн тэмдэг, 17 дугаартай хяналтын улсын байцаагчийн тэмдгийг хүлээн авч хадгалахыг Баянгол дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс (Ө.Өлзийбаасан)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус үүрэг болгосугай.

142500570

5. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл улсын ахлах бүртгэгч Б.Дэлгэртүвшинд тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

У.БОЛДХҮҮ

